



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 4/48

Улаанбаатар хот


“ШУТИС-ийн технологи дамжуулах журам” батлах тухай

“ШУТИС-ийн дүрэм”-ийн 2.6, 4.14.7 дахь заалт, Захирлын зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “ШУТИС-ийн технологи дамжуулах журам”-ыг хавсралтаар баталж, 2018 оны 03 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Батлагдсан журмыг мөрдөж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал /Т.Намнан/, бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, төвүүдийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ



ШУТИС-ИЙН ТЕХНОЛОГИ ДАМЖУУЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Журмын зорилго, хамрах хүрээ

- 1.1. Шинжлэх ухаан, технологийн их сургууль /цаашид ШУТИС гэх/ судалгааны их сургууль болж хөгжих, нийгэмд үйлчлэх үүргээ хэрэгжүүлэх нэг гол чиглэл бол технологи дамжуулалт юм.
- 1.2. ШУТИС-ийн технологи дамжуулах журам /цаашид “Журам” гэх/-ын зорилго нь ШУТИС-ийн эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааг хөгжүүлэх, судалгааны ажлын үр дүнд бий болсон шинэ болон сайжруулан хөгжүүлсэн мэдлэг, технологи, оюуны бүтээлийг зах зээлд нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагаанд баримтлах зарчим, удирдлага, зохион байгуулалт, оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэх, тэдгээрийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, эдгээр үйл ажиллагаанаас олсон орлого, ашгийг хуваарилахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.3. Энэхүү журам нь ШУТИС-ийн бүрэлдэхүүн болон харьяа сургууль, нэгжүүдийн дангаараа болон бусадтай хамтран хэрэгжүүлсэн бүх төсөл, хөтөлбөр, судалгааны ажилд хамаарна.

2 дугаар зүйл. Нэр томьёо

- 2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
 - 2.1.1. “Оюуны бүтээл” гэж нээлт, ноу-хау, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдэг, зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрхийн бүтээл зэрэг эрхийн хамгаалалт хийлгэх боломжтой эсэхээс үл хамааран оюуны өмчийн эрхэд хамаарах бүх бүтээлийг;
 - 2.1.2. “Технологи сайжруулах” эсвэл “технологи хөгжүүлэх” гэж өөрсдийн бий болгосон эсвэл нийтэд илэрхий болсон технологийг сайжруулан хөгжүүлэхийг;
 - 2.1.3. “Судлаач” гэж ШУТИС-ийн профессор, багш, эрдэм шинжилгээний ажилтан, ажилтан, оюутан, магистр, докторантыг;
 - 2.1.4. “Зочин судлаач” гэж ШУТИС-ийн хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт гаднын байгууллагаас гэрээний дагуу оролцож байгаа мэргэжилтнийг;
 - 2.1.5. “Суралцагч” гэж ШУТИС-ийн оюутан, магистрант, докторантыг;
 - 2.1.6. “Технологи задлах” гэж судалгаа шинжилгээний ажлын үр дүнд бий болсон оюуны бүтээлийг Оюуны өмч, технологи дамжуулах асуудал хариуцсан нэгж (ОӨТДАХН)-д анх удаа мэдээлэхийг;
 - 2.1.7. “Нууц” гэж технологи задлах үед “Оюуны бүтээлийн нууцлалын гэрээ”-гээр баримтжуулсан оюуны бүтээлийн тухай мэдээллийг;
 - 2.1.8. “Оюуны өмчийн эрх” гэж оюуны бүтээлийг ашиглах онцгой эрхийг;
 - 2.1.9. “Оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэх” гэж шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдгийг ашиглах онцгой эрх олж авахыг;

